ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 06 сарын 29 өдөр Дугаар А/100 Хужирт сум

Тендер хүчингүй болгож, гэрээ шууд байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу “2 дугаар Цэцэрлэгт хүнсний материал нийлүүлэх ӨВАХУСЗДТГ201801010/2” тендерийн “Хүнсний ногоо” буюу 4 дүгээр багцыг хүчингүй болгосугай.

2. Шууд гэрээ байгуулж, гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч (Ш.Эрдэнэхорол)-д даалгасугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

141 1199

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 06 сарын 29 өдөр        Дугаар А/101        Хужирт сум

Тендер хүчингүй болгож, гэрээ шууд
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу 1 дүгээр Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх ӨВАХУСЗДТГ201801011/2" тендерийн "Сүү, сүүн бүтээгдэхүүн" буюу 2 дугаар багцыг хүчингүй болгосугай.

2. Шууд гэрээ байгуулж, гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг 1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч (З.Оюунчимэг)-д даалгасугай.

ДАРГА                Р.ЛХАГВАСҮРЭН

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 07 сарын 02 өдөр Дугаар А/102 Хужирт сум

## Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 1, 2, 4, 6 дугаар багийн сонгогдсон зорилтот бүлгийн иргэдэд “Хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх дэлгүүр сонгох” ӨВАХУСЗДТГ/201803016/02 тендерийг “Хужирт нутаг” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн халамжийн ажилтан (Ё.Даариймаа)-д даалгасугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

141 1203

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 07 сарын 02 өдөр Дугаар А/103 Хужирт сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын "Газар өмчлүүлэх тухай" 2005 оны 81 тоот захирамжийн 23, 2005 оны 122 тоот захирамжийн 15, 2008 оны 69 тоот захирамжийн 18 дугаарт байгаа 3 өрхийн нэр бүхий 10 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

141 1205

Хужирт сумын Засаг даргын 2018 оны
07 дугаар сарын 02 -ны өдрийн А/103 тоот
захирамжийн хавсралт

Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

| өрхийн дугаар | Д/д | Өмчлөгчийн | | | | | | Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо | Газрын | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Овог | Эцэг /эх/-ийн нэр | Өөрийн нэр | Оршин суугаа хаяг | Регистр | 16 нас хүрэгүй өмчлөгчийн гэрчилгээний дугаар | | Байршил | Хэмжээ /м2/ | Газрын үнэ /мян.төг/ |
| А | 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 23 | 1 | Хөхөө | Нармандах | Мягмарсүрэн | 5-р баг | ЙС01261915 | | 2008.07.21 80 | 5-р баг Шунхлай 9-10 тоот | 886 | 637920 |
| | 2 | Боржигин | Ширчин | Анхбаяр | 5-р баг | ЙС92120616 | | | | | |
| 15 | 3 | Тойн | Ишдорж | Должинсүрэн | 5-р баг | ЙС65122005 | | 2005.12.01 122 | 5-р баг Гуа 21-3 тоот | 1962 | 1412640 |
| | 4 | Дархан | Энхбат | Жалмаа | 5-р баг | ЙС83100800 | | | | | |
| | 5 | Дархан | Энхбат | Эрхэмбаяр | 5-р баг | ЙС88040817 | | | | | |
| 18 | 6 | Чимэгт | Жамсрандорж | Оюунцэцэг | 5-р баг | Н368070361 | | 2008.05.16 19 | 5-р баг Шунхлай 22-10 тоот | 1427 | 1027440 |
| | 7 | Монгол | Нямсүрэн | Оюунбилэг | 5-р баг | ЙС95051006 | | | | | |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 07 сарын 03 өдөр Дугаар А/104 Хужирт сум

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 (а), Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 2018 оны 7 дугаар сарын 3-ны өдрөөс 7 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд чанартай зохион байгуулахыг “Гонир манал”, мал эмнэлэг үржлийн нэгжийн эмч (Ш.Байгальмаа), техникч (Г.Отгон), (С.Шаатар), (Д.Осоржамаа) нарт тус тус даалгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч (Б.Ичинхоролцэвэлмаа), Мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн (С.Самдан), 3 дугаар багийн Засаг дарга (Д.Галиндэв) багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга (Т.Даваадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

2581 397

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 07 сарын 03 өдөр Дугаар А/105 Хужирт сум

**Сумын бэлчээр ашиглалтын ажлын хэсэг байгуулах тухай**

**Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.21, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:**

**1. Сумын бэлчээр ашиглалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.**

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Д.Төмөр | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга |
| Гишүүд: | Д.Мөнхбат | Газрын даамал |
| | Ц. Нямдорж | Газар тариалан, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн |
| | Б.Ичинхоролцэвэлмаа | Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч |
| | С.Самдан | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн Технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн |
| | Б.Пагамдулам | 1 дүгээр багийн засаг дарга |
| | Д.Батбаян | 2 дугаар багийн Засаг дарга |
| | Д.Галиндэв | 3 дугаар багийн Засаг дарга |
| | Ц.Амгалан | 6 дугаар багийн Засаг дарга |

**2. Сумын бэлчээрийн менежментийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, мөрдөж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Төмөр)-д даалгасугай.**

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

141 1219

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 07 сарын 03 өдөр Дугаар А/106 Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Өндөр сант хайрханы тахилгыг тайх ёслолын арга хэмжээний зардалд 2050000 ( хоёр сая тавин мянга) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

2501 212

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 03 өдөр Дугаар А/107 Хужирт сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (г) дахь заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын (ахлах) байцаагчийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор сумын Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, эрсдлийг бууруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | О.Долгормаа | Соёлын төвийн эрхлэгч |
| Гишүүд: | З.Цэцэгмаа | Байгаль орчны хяналтын Улсын Байцаагч |
| | Д.Галиндэв | 3 дугаар багийн Засаг дарга |
| | Д.Мөнхбат | Газрын даамал |
| | О.Алтанчимэг | Байгаль хамгаалагч |

2. Зөвлөмжийн дагуу эрсдлийг бууруулах, гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан ажиллахыг ажлын хэсэгт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 9 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (О.Долгормаа)-д даалгасугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

2501 213

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 07 сарын 05 өдөр Дугаар А/108 Хужирт сум

Эрх зүйн сургалт, сурталчилгааны
баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 (а) дахь заалт, аймгийн Засаг даргын 2018 оны "Эрх зүйн сургалт, сурталчилгааны талаар авах арга хэмжээний тухай" А/78 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн боловсрол олгох, хууль тогтоомжийг олон нийтэд ойлгуулах, эрх зүйн мэдээллийг бэлтгэн түгээх орон тооны бус сумын эрх зүйн сургалт, сурталчилгааны багийг хавсралтаар байгуулсугай.

2. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээллэх, нийтэд сурталчлахтай холбогдсон үүргийг төрийн албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тодорхой тусган биелэлтийг дүгнэж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.

3. Эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ажлын хэсэгт, эрх зүйн сургалт сурталчилгааны хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Энхтүвшин), тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гарган холбогдох байгууллагад хүргүүлж байхыг Нарийн бичгийн дарга (Л.Цэдэв) нарт тус тус даалгасугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

2501 215

Сумын Засаг даргын 2018 оны 07.....
дугаар сарын 05.....-ний өдрийн А/108 дугаар
захирамжийн хавсралт

Сумын “Эрх зүйн сургалт, сурталчилгааны баг”-ийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч: Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Төрийн захиргааны түшмэл

Гишүүд: Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан

Нийгмийн халамжийн ажилтан

Нийгмийн даатгалын тасгийн дарга

Цагдаагийн тасгийн Хэсгийн төлөөлөгч

Цагдаагийн тасгийн Замын Цагдаагийн зохицуулагч

Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Газрын даамал

Татварын байцаагч

Мал эмнэлэг хорио цээрийн хяналтын улсын байцаагч

Улсын бүртгэгч

Хөдөлмөрийн ажилтан

Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн

Насан туршийн боловсролын арга зүйч, багш

-оОо-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 16 өдөр　　Дугаар А/109　　Хужирт сум

## Ажлын байрны тодорхойлолт батлах тухай

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ажлын байр (албан тушаал)-ын тодорхойлолт боловсруулах заавар"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын даргын ажлын байрны тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2. Ажлын байрны тодорхойлолтын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг байгууллагын Дотоод хяналтын багийн ахлагч (Л.Цэдэв)-т даалгасугай.

ДАРГА　　Р.ЛХАГВАСҮРЭН

25 01217

Сумын Засаг даргын 2018 оны
07 -р сарын 16-ны өдрийн
А/109 захирамжийн хавсралт

# АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

## А.ТАНИЛЦУУЛГА

| | | |
|---|---|---|
| 1. Байгууллагын нэр: Хужирт *сумын Засаг даргын Тамгын газар* | 2. Нэгжийн нэр. *Засаг даргын Тамгын газар* | |
| 3. Ажлын байрны нэр. *Сумын Засаг даргын Тамгын газрын дарга* | 3.1.Албан тушаалын ангилал. Ахлах түшмэл. | 3.2.Албан тушаалын зэрэглэл. *ТЗ-7* |
| 4.Ажлын байрыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: *Сумын Засаг дарга,* | 4.1.Албан тушаалын ангилал: *УТАХ,* | 4.2.Албан тушаалын зэрэглэл: |
| 5.Ажлын байрыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: | 5.1.Албан тушаалын нэр | 5.2.Албан тушаалын эрхлэгчдийн тоо *29* |

## Б.ЧИГ ҮҮРЭГ

| | |
|---|---|
| 1.Ажлын байрны зорилго | Сумын Засаг даргын Тамгын газрын зорилт чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж Засаг даргыг бодлогын зөвлөгөө, мэргэшлийн дэмжлэгээр хангах, орон нутгийн төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, Тамгын газрын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх |

| 2.Ажлын байрны үндсэн зорилт | 2.1.Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт |
|---|---|
| 1.Сумын Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд хамрах асуудлаар бодлого боловсруулах хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж Тамгын газрыг мэргэшлийн түвшинд удирдах | 1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хүнд суртал чирэгдэлгүй хөнгөн шуурхай болгон хэвшүүлсэн байна. ЗДТГазрын үйл ажиллагааны жилийн болон хэтийн төлөвлөгөө журам, зааврын дагуу боловсрогдон төлөвлөгдсөн асуудал бүрэн хэрэгжсэн байна. |
| 2. Тамгын газрын төсөв санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх | 2. Гэрээ заавар стандартын дагуу боловсруулагдан баталгаажиж биелэлт үр дүнг хугацаанд нь тооцсон байна. ЗДТГазар төсвийн зөрчилгүй ажилласан байна. |
| 3.“Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”, “Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээ”, “Сумын эдийн засаг, нийгэм хөгжүүлэх үндсэн чиглэл” зэргийн хэрэгжилт, явцад хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах асуудлыг хариуцан зохион байгуулах. | 3. “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”, “Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээ”, “Сумын эдийн засаг, нийгэм хөгжүүлэх үндсэн чиглэл”-д хяналт-шинжилгээ хийгдэж, үнэлгээ дүгнэлт өгөгдөж хэрэгжилт 95-с дээш хувьтай байна. |
| 4. Нутгийн захиргааны байгууллагын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн албан хаагчдын сургалтын үйл ажиллагаа. | 4.Төрийн албан хаагчдын мэргэшил, ур чадвар сайжирч үйл ажиллагааны үр дүн дээшилсэн байна. |

| | |
|---|---|
| 5. Батлан хамгаалах болон гамшигаас хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангах ажлыг хариуцан бодлого зохицуулалтаар хангах. | 5.Батлан хамгаалах болон онцгой байдлын арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн байна. (Болзошгүй цагийн байдал үүссэн үед шуурхай ажилласан байна.) |
| 6. Сумын Засаг дарга, түүний Тамгын газрын хэмжээнд төрийн нууцын асуудлыг хариуцах. | 6.Төрийн нууцын хууль, тогтоомжийн талаар зөрчилгүй байна. |
| 7. Сумын ИТХ-ын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, ИТХ-тай харилцан ажиллах | 7.ИТХ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж хэвшсэн байна. |
| 8. Багийн Засаг дарга нарын үйл ажиллагаанд хяналт тавьж мэргэшил арга зүйн удирдлага зохицуулалтаар хангах. | 8. Багийн Засаг дарга нарын ажлыг тогтмол дүгнэж хэвшсэн тэдний үйл ажиллагааны үр дүн дээшилсэн байна. |
| 9. Авилгын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангуулах, ашиг сонирхолын зөрчлийг бүртгэх, хасхом тайланг гаргуулах | 9.Авилгын эсрэгхуулийн хэрэгжилтийг хангагдсан байна. |

| 3.Ажлын байрны гол үйл ажиллагаа | 3.1.Хугацаа хуваарь |
|---|---|
| Ажлын байрны 1 дүгээр үндсэн зорилтын хүрээнд | |
| 1.1.Сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг оны эхэнд заавар журмын дагуу шинэчлэн боловсруулуулж баталгаажуулан мөрдүүлэх<br>1.2.Ажилтнуудын хийсэн ажлын сар бүрийн жагсаалтыг гаргуулан авч дүгнэлт хийж, холбогдох арга хэмжээ авах.<br>1.3.Сумын Засаг дарга,Тамгын газрын сард гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг гарган, аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны удирдлагын “ хэлтсийн ХШҮДА-ын албанд хүргүүлэх<br>1.4.Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн үүрэг үйл ажиллагааны төлөвлөгөө хэрхэн хэрэгжиж байгааг сар бүр хянан гүйцэтгэлийг тооцож ажиллах.<br>1.5.Ажилтнуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ жигд хангаң биелүүлэхэд нь удирдлага туслалцаа үзүүлж зохицуулах, зохион байгуулах арга хэмжээг авах, тэднийг байнгын зөвлөгөө дэмжлэгээр хангах.<br>1.6.Ажилтнуудад үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг бодитой үнэлж, үр дүнгийн гэрээний хэрэгжилтээр зэрэг дэв олгох, бууруулах цалинг өөрчлөн тогтоох асуудал боловсруулан төрийн албаны салбар зөвлөл болон холбогдох албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх тэднийг тогтоосон журмын дагуу урамшуулах, шагнуулахаар холбогдох байгууллагуудад уламжлах.<br>1.7.Тамгын газрын ажилтнуудад амралт, чөлөө олгох, үйл ажиллагааг нь түр зохицуулах,ажлыг нь орлон гүйцэтгүүлэх аймаг, баг, байгууллагуудад томилолтоор ажиллуулах зэрэг асуудлуудыг дотоод журам, дүрэмд заасны дагуу шийдвэрлэх.<br>1.8.Хугацаатай албан бичгийн болон ажилтнуудад өгөгдсөн хугацаатай үүргүүдийн шийдвэрлэлтэд биечлэн хяналт тавьж гүйцэтгүүлэх ажлыг анхааралдаа авч ажиллах.<br>1.9. ЗДТГазрын төсвийн ерөнхийлөн захирагчтай төсвийн шууд захирагчийн байгуулах үр дүнгийн гэрээ болон хэтийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, биелэлтийн тайлагнах мэдээлэх ажлыг хариуцах.<br>1.10.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийтээр буюу эрх бүхий албан тушаалтан, ажил үйлчилгээ эрхлэгчдийн дагаж мөрдөх Монгол улсын хууль, тогтоомж, эрх зүйн бусад актын хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангуулах, биелэлтийг тооцох, мэдээлэх асуудлуудыг сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны түшмэлийн ажлын | 30 |

| | |
|---|---|
| байрны тодорхойлолтод тусган баталгаажуулж хяналт тавих.<br>1.11.Сумын Засаг даргын бүрэн эрхийн хүрээний асуудлаар бодлого боловсруулах, шийдвэрийн төсөл бэлтгэх, түүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажлын албыг зохион байгуулан удирдах<br>1.12.Иргэний 8 төрлийн бүртгэлийн хөтлөлт, иргэний үнэмлэх олголтын материалыг эцэслэн хянаж гарын үсэг зурж баталгаажуулах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх<br>1.13.Тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад ажил. | |
| *Ажлын байрны 2 дугаар үндсэн зорилтын хүрээнд* | |
| 2.1.Сумын Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулан түүний явц, биелэлтийг тооцон хэрэгжилтийг хангах<br>2.2.Баримт бичгүүд, үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг байгууллагын өмнө тавигдаж байгаа зорилтуудыг харгалзан ажилтнуудын тухайн оны гэрээнд тусгах зорилтуудыг тэдэнтэй зөвшилцөн тодорхойлох.<br>2.3.Ажилтнуудыг тухайн оны бодлогын зорилтуудтай уялдуулан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад нь арга зүйгээр хангах, түүнийг батлах, биелэлтэд нь хяналт тавьж гүйцэтгэлийг хангуулах<br>2.4.Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдын үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд байнга хяналт тавьж, улирал тутам тайлан гаргуулах, дүгнэж тооцох<br>2.5.Сумын Засаг даргын аймгийн засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хариуцах салбар, ажилтнуудыг тодорхой болгон баталгаажуулж хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон дүгнэж Засаг даргыг мэдээллээр хангах<br>2.6.Үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт | 25 |
| болон бусад ажлын үр дүнгээр ажилтнуудын цалин нэмэгдлийг өөрчлөх, урамшуулах асуудлыг Засаг дарга,орлогч нартай хамтран шийдвэрлэх.<br>2.7.Тамгын газрын төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулж санхүү, төсвийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлэх<br>2.8.Төрийн зарим ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх ажлыг хариуцаж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан хэрэгжилтэд байнгын хяналт тавьж түүний явц, эцсийн үр дүнг тооцон дүгнэх | |
| *Ажлын байрны 3 дугаар үндсэн зорилтын хүрээнд* | |
| 3.1.”Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”, “Сумын эдийн засаг, нийгэм хөгжүүлэх үндсэн чиглэл”,сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээ”-ний хэрэгжилт, биелэлтийн явцад хяналт шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээлэх, тайлагнах<br>3.2.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт нэг бүрт хувийн хэрэг нээж тодорхой албан тушаалтнуудад хариуцуулан баяжилт хийлгэн, биелэлтийн явцыг байнга тооцуулах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх.<br>3.3.Хяналт шинжилгээний дүнг үндэслэн ”Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”, “эдийн засаг, нийгэм, байгаль орчныг хөгжүүлэх үндсэн чиглэл”, сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан “Үр дүнгийн гэрээ”-ний хэрэгжилтийг тодорхой давтамжтайгаар хэлэлцэж, дүгнэлт гаргах.<br>3.4.Тухайн чиг үүрэгтэй холбоотой бусад ажил. | 10 |
| Ажлын байрны 3 дугаар үндсэн зорилтын хүрээнд | |
| 4.1.Суманд хүний нөөцийг бүрдүүлэх, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны чанар үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтаар хангах.<br>4.2.Төрийн байгууллагыг төрийн мэргэшсэн ажилтнаар хангах зорилгоор хүний нөөцийн хэрэгцээг тогтоох, төлөвлөх, сургалтыг тодорхойлж, ойрын болон хэтийн бодлого, хөтөлбөр боловсруулан мөрдөж ажиллах. | |

| | |
|---|---|
| 4.3.Удирдах ажилтнуудыг сургах хэрэгцээг тодорхойлж, тэднийг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах.<br>4.4.Төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулж, түүний үр дүнг харгалзан холбогдох арга хэмжээ авах.<br>4.5.Төрийн албаны зөвлөлөөс зарласан ажлын байранд ажиллах хүмүүсийн мэдээлэх, мэргэшлийн шалгалтад орох ажилтнуудын бэлтгэлийг хангуулах, тэднийг зөвлөгөө, дэмжлэгээр хангах шалгалт өгүүлэх ажлыг зохион байгуулах. | 5 |
| 4.6.Сумын Засаг даргын шийдвэрээр ажлын байр нь зохицуулагдах албан хаагчдын сонгон шалгаруулалтын шийдвэрийн төслийг боловсруулж баталгаажуулах.<br>4.7.Төрийн албаны зөвлөлийн журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын зөвлөмжийг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газарт хадгалагдах хувийн хэргийг бүрдүүлэх, суманд байвал зохих ажилтнуудын хувий□ хэргүүдийг бүрдүүлж баяжилт хийж байх.<br>4.8.Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлэх.<br>4.9.Төрийн албатай холбоотой хууль,тогтоомжийн лавлагааны сан бүрдүүлж ашиглах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.<br>4.10.Тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдолтой бусад ажил. | |
| Ажлын байрны 5 дугаар үндсэн зорилтын хүрээнд | |
| 5.1.Батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангах ажлыг хариуцаж, бодлого зохицуулалтаар хангах. /Нууцын зэрэглэлтэй/<br>5.2.Сумын орон тооны бус онцгой байдлын штабыг ахлан үүссэн цаг байдлыг шуурхай удирдлагаах ханган ажиллах. | 5 |
| Ажлын байрны 6 дугаар үндсэн зорилтын хүрээнд | |
| 6.1. Сумын Засаг дарга, түүний Тамгын газрын түвшинд төрийн нууцын асуудлыг хариуцаж ажиллах.<br>6.2.Төрийн нууцыг хадгалах, ашиглах үйл ажиллагааг зохих хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулах.<br>6.3.Төрийн нууцын талаар аймгийн Засаг даргын тамгын газар, Тагнуулын хэлтэстэй ажил хэргийн байнгын харилцаатай ажиллах | 5 |
| Ажлын байрны 7дугаар үндсэн зорилтын хүрээнд | |
| 7.1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах<br>7.2.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэргүүлэгчдэд үйл ажиллагагаагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх<br>7.2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай харилцан ажиллах | 5 |
| Ажлын байрны 8-р үндсэн зорилтын хүрээнд | |
| 8.1 Багийн Засаг дарга нарыг хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах, дэмжлэг үзүүлэх<br>8.2..Багийн Засаг дарга нарын сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж удирдлага, мэргэшил арга зүйн туслалцаа үзүүлэх.<br>8.3.Багийн Засаг дарга нарын сар бүр хийсэн ажлын жагсаалтыг авч дүгнэлт хийх.<br>8.4.Үр дүнгийн гэрээний нь хэрэгжилт явцыг улирал бүр тооцож жилийн эцсээр нэгтгэн дүгнэх.<br>8.5.Багийн Засаг дарга нарын үйл ажиллагааны үр дүнг харгалзан тэдний цалинг өөрчлөн тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх.<br>8.6.Багийн Засаг дарга нарын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардагдах хүний нөөц болон төсөв ,санхүүгээр хангах | 10 |

| | | |
|---|---|---|
| | 3.3.Хүний | Тамгын газрын ажилтнууд |
| | 3.4.Бусад | |
| 4.Ажлын байрны нөхцөл | 4.1.Ердийн нөхцөл | хэвийн |
| | 4.2.Онцгой нөхцөл | |

Д.БАТАЛГААЖУУЛАЛТ

| Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан | Ажлын байрны тодорхойлолтыг баталсан |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: *Засаг даргын Тамгын газрын* Төрийн Захиргааны Түшмэл<br>/Тамга/<br>____________ ____________________<br>/гарын үсэг /Эцэг ,эхийн эхний үсэг,өөрийн нэр/<br><br>20... оны .....-р сарын .....-ны өдөр. | Албан тушаалын нэр: *Сумын Засаг дарга*<br><br>/Тамга/<br>____________ ____________________<br>/гарын үсэг /Эцэг ,эхийн эхний үсэг,өөрийн нэр/<br><br>20.... оны ......-р сарын ......-ны өдөр. |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 17 өдөр Дугаар А/110 Хужирт сум

Ардын хувьсгалын 97 жилийн ойн
сумын баяр наадмын ажиллагааг зохион
байгуулах комиссыг батлах тухай

Монгол улсын Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны “Баяр наадам тэмдэглэх хугацааны тухай” 122 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 97 жилийн ойн сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

| | | |
|---|---|---|
| Комиссын дарга: | Ж.Оюунгэрэл | Засаг даргын орлогч |
| Гишүүдэд: | Д.Энхтүвшин | ЗДТГ-ын дарга |
| | Д.Төмөр | ИТХ-ын Нарийн бичгийн дарга |
| | О.Долгормаа | Соёлын төвийн эрхлэгч |
| | Х.Түмэнбаяр | Цагдаагийн тасгийн дарга |
| | Ч.Буянбат | Нягтлан бодогч |
| | Ж.Шижээ | “Хужирт эрдэс баялаг”ОНААТГ-ын дарга |

2. Сумын баяр наадмыг зохион байгуулах салбар комиссыг хавсралтаар баталсугай.

3. Сумын баяр наадмыг 2018 оны 7 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Засгийн газраас баталсан зохих журам, зааврын дагуу зохион байгуулахыг комисс (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

141 1219

Засаг даргын 2018 оны 07 сарын
17 –ны өдрийн А/110 дугаар захирамжийн
хавсралт

Бөхийн комисс:

| | | |
|---|---|---|
| Дарга: | Ж.Шижээ | "Хужирт эрдэс баялаг"ОНААТГ-ын дарга |
| Гишүүд: | Д.Мягмарсүрэн | 4-р багийн ИНХурлын дарга |
| | А.Хүрэлбаатар | ЭМТ-ийн мэс заслын их эмч |
| | А.Отгонбаатар | ЕБСургуулийн багш |
| | Э.Батзаяа | ЕБСургуулийн багш |

Морины комисс:

| | | |
|---|---|---|
| Дарга: | Д.Төмөр | ИТХ-ын нарийн бичгийн дарга |
| Гишүүд: | Т.Баярмөнх | Хужирт ажнай МСУХ-ны тэргүүн, ЕБСургуулийн захирал |
| | З.Цэцэгмаа | БОХУ-ын байцаагч |
| | О.Алтанчимэг | Байгаль хамгаалагч |
| | Г.Цоодол | ХГБАХМэргэжилтэн |
| | Н.Баярцэцэг | ЭМТ-ийн эрхлэгч |
| | Т.Энхжаргал | Хөдөлмөрийн ажилтан |
| | С.Самдан | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн |
| | О.Мягмарсүрэн | Малын эмч |
| | Д.Батбаян | 2-р багийн Засаг дарга |
| | Д.Галиндэв | 3-р багийн Засаг дарга |
| | Д.Батбаяр | 4-р багийн Засаг дарга |
| | Ц.Амгалан | 6-р багийн Засаг дарга |
| | С.Жамбалжав | ЗДТГ-ын жолооч |
| | Ч.Бат-Эрдэнэ | Аж ахуйн хашааны сахиул |

Соёл, спорт олон нийтийн комисс:

| | | |
|---|---|---|
| Дарга: | О.Долгормаа | Соёлын төвийн эрхлэгч |
| НБ-ийн дарга: | Б.Лхагвадулам | Номын санч |
| Гишүүд: | Д.Энхцэцэг | Хөгжмийн багш |
| | Т.Баярцэрэн | Биеийн тамир, спорт хариуцсан мэргэжилтэн |
| | Б.Ганпүрэв | Биеийн тамирын багш |

| | | |
|---|---|---|
| | Ж.Мандах | Эрчим хүчний эрхлэгч |

Хэв журмын комисс:

| | | |
|---|---|---|
| Дарга: | Х.Түмэнбаяр | Цагдаагийн тасгийн дарга |
| Гишүүд: | Д.Батбаяр | Цагдаагийн хэсгийн төлөөлөгч |
| | Б.Алтансүх | Замын цагдаагийн зохицуулагч |
| | Б.Мөнх-Эрдэнэ | Мөрдөн байцаагч |
| | Ц.Базарваань | Хэв журмын цагдаа |
| | Б.Цэрэннадмид | Татварын байцаагч |
| | Б.Ичинхоролцэвэлмаа | МАХЦЧХУБайцаагч |

Аж ахуйн комисс:

| | | |
|---|---|---|
| Дарга: | Д.Энхтүвшин | ЗДТГ-ын дарга |
| Гишүүд: | Ч.Буянбат | Санхүүгийн албаны дарга |
| | Л.Цэдэв | ТЗАХТүшмэл |
| | Г.Оюунмандах | ЗДТГ-ын ня-бо |
| | Д.Уранчимэг | Төрийн сангийн мэргэжилтэн |
| | Ч.Байгалмаа | Нийгмйин даатгалын тасгийн дарга |
| | Ё.Даариймаа | Халамжийн ажилтан |
| | Л.Сувд-Эрдэнэ | Нягтлан бодогч |
| | Ч.Оюунцэцэг | Нягтлан бодогч |
| | Ц.Галбадрах | Нийгмийн даатгалын байцаагч |
| | М.Чимэдрэгзэн | Архив, бичиг хэргийн ажилтан |
| | Ч.Даваадулам | Нийгмийн даатгалын байцаагч |
| | Ц.Лхамролом | 5-р багийн Засаг дарга |
| | Б.Жаргал | Үйлчлэгч |
| | С.Ялалт | ИТХ-ын жолооч |
| | Д.Мөнхбат | Газрын даамал |
| | Ц.Галбаатар | Нийгмийн даатгалын байцаагч |
| | Б.Пагамдулам | 1 дүгээр багийн Засаг дарга |
| | Б.Пүрэвжав | Нягтлан бодогч |
| | Х.Дагвацэрэн | Машинист |
| | Д.Галбаатар | Усны тэрэгний жолооч |
| | Т.Батболд | Машинист |
| | Ц. Зундуй | Машинист |
| | Б. Батбаатар | Машинист |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 07 сарын 22 өдөр Дугаар А/111 Хужирт сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а”, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 20 дугаар зүйл, Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2014 оны а/93/ дугаар тушаал, Засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах, хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох, уг бүсэд үйл ажиллагаа явуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 1 дүгээр багийн Ар булаг, Модот гэдэг газарт нутаглаж буй Өлзийт сумын малчин Т.Мөнхбат, С.Ариунжаргал нарын хотонд мал амьтны гоц халдварт шүлхий өвчин илэрсэн тул хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалтын дэглэмийн үеэр хяналтын пост гаргаж техник хэрэгсэл, хүн хүч дайчлан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Тамгын газрын дарга (Д.Энхтүвшин)-д, дэглэм тогтоосон бүс нутгийг тойрон мотоцикльтой эргүүл ажиллуулахыг Мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн (С.Самдан), хүн хүч хоол хүнс, шатах тослох материал, халдваргүйжүүлэлтийн хувцас хэрэгсэл, ариутгалын бодисоор хангаж ажиллахыг Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Буянбат) нарт тус тус даалгасугай.

3. Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан үзвэр үйлчилгээ хурал, цуглаан, урлагийн тоглолт , спортын арга хэмжээ, баяр наадам, уул, ус овоо тахих, хурдан морины уралдааныг тус тус зохион байгуулахгүй байхыг сумын Баяр наадмын комиссын дарга (Ж.Оюунгэрэл), “Хужирт ажнай” морин спорт уяачдын

141 1221

холбооны дарга (Т.Баярмөнх), Бөхийн холбооны дэд тэргүүн (Ж.Шижээ), аж ахуй нэгж, байгууллагын дарга эрхлэгч нарт тус тус даалгасугай.

4. Хязгаарлалтын дэглэмд томилогдон ажиллаж байгаа гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн албан хаагчид, иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай эм тарианы нөөцийг бүрдүүлэх, эрсдэлтэй бүсийн судалгааг гаргаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч (Н.Баярцэцэг)–д даалгасугай.

5. Тухайн нутаг дэвсгэрт нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, тээврийн хэрэгсэл болон хүн малын хөдөлгөөнд хяналт тавьж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, хошууч (Х.Түмэнбаяр)-т даалгасугай.

6. Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан малчид, мал бүхий иргэд үүрэг болгох нь:

а. Мал амьтан гэнэт олноор хорогдсон, халдварт өвчний сэжиг илэрсэн тохиолдолд 12 цагийн дотор дуудлага өгч мэдэгдэх.

б. Халдварт өвчин гарсан бүс нутгаас малын шилжилт хөдөлгөөн болон малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн худалдан авахгүй байх.

7. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох заавар, зөвлөмжийн дагуу иргэдэд сурталчилж ажиллахыг Хувийн мал эмнэлэг, аж ахуйн нэгжийн малын эмч Ц.Батдэлгэр, Ш.Байгальмаа болон багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Б.Ичинхоролцэвэлмаа)–д даалгасугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 24 өдөр Дугаар А/112 Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Тогтвортой амьжиргаа -3" төслөөс сумын 2017 оны Орон нутгийн хөгжлийн санд үнэлгээ хийх ажлын хэсэг орон нутагт ирж ажилласантай холбогдуулан хоолны зардалд 53000 (тавин гурван мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

2501 223

Сумын Засаг даргын 2018 оны
07-р сарын 24-ны өдрийн А/112-р
захирамжийн хавсралт

| № | Зардлын төрөл | Нэгжийн тоо | Нэгж ноогдох мөнгөн дүн | Нийт мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Банштэй цай | 5 | 5000 | 25000 |
| 4 | Гуляш | 5 | 5000 | 25000 |
| 5 | Цай | 1 | 3000 | 3000 |
| | Бүгд | | | 53.000 |

-оОо-

-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 07 сарын 27 өдөр Дугаар А/113 Хужирт сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 (б) дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн зөн Арвайхээр Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс эдийн засгийн төслийн хүрээнд зохион байгуулж буй малжуулах төсөлд хамрагдах малчдыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Ж.Оюунгэрэл | Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн дарга: | Т.Энхжаргал | Хөдөлмөрийн ажилтан |
| Гишүүд: | Б.Ичинхоролцэвэлмаа | Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч |
| | Б.Пагамдулам | 1 дүгээр багийн Засаг дарга |
| | Д.Батбаян | 2 дугаар багийн Засаг дарга |
| | Д.Галиндэв | 3 дугаар багийн Засаг дарга |
| | Д.Батбаяр | 4 дүгээр багийн Засаг дарга |
| | Ц.Лхамролом | 5 дугаар багийн Засаг дарга |
| | Ц.Амгалан | 6 дугаар багийн Засаг дарга |

2. Малжуулах төсөлд хамруулах өрхүүдийг сонгох, малчдаас худалдах малын үнийн санал авах ажлыг Дэлхийн зөн Арвайхээр Орон нутаг хөгжлийн хөтөлбөрийн ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

ДАРГА Р. ЛХАГВАСҮРЭН

141 1225

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 08 сарын 01 өдөр Дугаар А/114 Хужирт сум

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мал амьтны, эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын 1 дүгээр багийн Ар булаг, Модот гэдэг газарт нутаглаж буй Өлзийт сумын малчин Т.Мөнхбат, С.Ариунжаргал нарын хотонд 7 хоногийн хязгаарлалтын дэглэмийн хугацаанд шүлхий өвчний шинж тэмдэг шинээр илрээгүй тул 2018 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Хязгаарлалтын дэглэм цуцалсан нутаг дэвсгэрийн хил залгаа байгаа мал амьтанд байнгын хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Б.Ичинхоролцэвэлмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

141 1127

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 01 өдөр  Дугаар А/115  Хужирт сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрмодот 1 дүгээр багийн нутаг дэвсгэр "Өрмөгтий" гэх газар нутаглаж байгаа малчин О.Чойжамцын 1 үхэрт мал амьтны халдварт галзуу өвчний шинж тэмдэг илэрч Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн 2018 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 15/02/331/08 тоот дүгнэлтээр батлагдсан тул 2018 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 14 хоног хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт байгаа 3 хот айлын 5 өрхийн 12 хүн, 1593 бог мал, 193 бод мал, 4 нохойг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулж, ариутгал халдваргүйжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг "Гуахарз" мал эмнэлгийн малын их эмч (Ц.Батдэлгэр), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Н.Баярцэцэг), 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Пагамдулам) нарт тус тус даалгасугай .

3. Холбогдох заавар журмын дагуу хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхтүвшин), уг захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлэгийн хяналтын улсын байцаагч (Б.Ичинхоролцэвэлмаа), Цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч дэслэгч (Д.Батбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Р.ЛХАГВАСҮРЭН

141 1129

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ**
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 08 сарын 14 өдөр    Дугаар А/116    Хужирт сум

**Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мал амьтны, эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Өвөрмодот 1 дүгээр багийн нутаг Өрмөгтий гэдэг газарт нутаглаж буй тус багийн малчин О.Чойжамцын хотонд хязгаарлалтын дэглэмийн хугацаанд галзуу өвчний шинж тэмдэг шинээр илрээгүй тул 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн А/115 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Хязгаарлалтын дэглэм цуцалсан нутаг дэвсгэрийн хил залгаа байгаа мал амьтанд байнгын хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Б.Ичинхоролцэвэлмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА    Р.ЛХАГВАСҮРЭН

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 04 өдөр Дугаар А/83 Хужирт сум

## Хагас жилийн малын түүвэр судалгаа авах Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 (г), Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 (в) дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 оны хагас жилийн малын түүвэр судалгааны ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга : | Ж.Оюунгэрэл | Засаг даргын орлогоч |
| Нарийн бичгийн дарга: | Д.Уранчимэг | Төрийн сангийн мэргэжилтэн |
| Гишүүд: | Б.Ичинхоролцэвэлмаа | Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч |
| | Б.Пагамдулам | 1 дүгээр багийн засаг дарга |
| | Д.Батбаян | 2 дугаар багийн Засаг дарга |
| | Д.Галиндэв | 3 дугаар багийн Засаг дарга |
| | Д.Батбаяр | 4 дүгээр багийн Засаг дарга |
| | Ц.Лхамролом | 5 дугаар багийн Засаг дарга |
| | Ц.Амгалан | 6 дугаар багийн Засаг дарга |

2. Хагас жилийн малын түүвэр судалгааны ажлыг батлагдсан удирдамж, графикийн дагуу 2018 оны 6 дугаар сарын 04-ны өдрөөс 2018 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн хооронд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Ж.Оюунгэрэл), нэгдсэн дүн мэдээг 6 дугаар сарын 11-ны дотор холбогдох газарт хүргүүлэхийг нарийн бичгийн дарга (Д.Уранчимэг) нарт тус тус даалгасугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

141 1165

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 04 өдөр Дугаар А/84 Хужирт сум

Дуудлага худалдааг дахин явуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 10.2 дахь заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны "2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 6/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын 5 дугаар багийн нутаг Улаан давааны өврт 1 га газрыг бордооны үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг 2018 оны 6 дугаар сарын 19-нд явуулсугай.

2. Дуудлага худалдаа явагдах зар мэдээг хуулийн дагуу иргэдэд мэдээлэхийг Газрын даамал (Д.Мөнхбат)-д, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (З.Цэцэгмаа) нарт үүрэг болгосугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

141 1167

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 04 өдөр Дугаар А/85 Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 6 дугаар багийн иргэн Д.Батболдын (йс78012418) эзэмшлийн 5 дугаар багийн нутаг НИК шатахуун түгээх станцын баруун талд байрлах 000439480 тоот гэрчилгээний дугаартай, 6211000141 тоот нэгж талбарын дугаартай үйлчилгээний зориулалттай 4200 м$^2$ газрын эзэмших эрхийг 40 жилийн хугацаатайгаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг Газрын даамал (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

141 1169

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

## АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

**Нэг. Нийтийн албан тушаалтан**

| | | |
|---|---|---|
| Ургийн овог: Борхан | Эцэг (эх)-ийн нэр: Хадхаа | Нэр: Лхагвасүрэн |
| Албан тушаал: Сумын Засаг дарга | Ажиллаж байгаа байгууллага: ЗДТГ Баядар | |
| Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: 2016.10.27 | Байгууллагын хаяг: ЗДТГ-ын байр | |
| Албан үүргийн төрөл: Удирдах. | Тайлбар: 2018.06.04.А/86. Хороолж гаргуулах | |

Сонирхлын зөрчилтэй эсэх Тийм Үгүй ✓

**Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал**

Нийтийн албан тушаалтан ______________________________ би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

**Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай**

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

______________________________

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

______________________________

байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:

______________________________

Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

______________________________

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

**Дөрөв. Баталгаажуулалт.**

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

Сумын Засаг дарга ....... /албан тушаал/    [гарын үсэг] ....... /гарын үсэг/    /Х.Лхагвасүрэн/ /нэр/

2018 он 06 сар 04 өдөр

**Шийдвэрлэсэн байдал**

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх

Тийм Үгүй

Хэрэв "Тийм" бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй

Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй

Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

**Баталгаажуулалт:**

....................... /албан тушаал/    ....................... /гарын үсэг/    /......................./ /нэр /

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 04 өдөр Дугаар А/86 Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэл журам"-ын 2.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны "Хүүхдийн хөгжил, хамгааллын жил болгон зарлах тухай" 06/05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны " Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн ажлын төлөвлөгөө батлах тухай" А/20 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүүхдийн хөгжил, хамгааллын жил"-ийн ажлын хүрээнд аймагт зохион байгуулагдах "Хүүхдийн урлагийн V их наадам"-д оролцоход шатахуун, бусад зардалд 1.348.970 (нэг сая гурван зуун дөчин найман мянга есөн зуун далан) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

14 1171

Засаг даргын 2018 оны 06-р
сарын 04-ны өдрийн А/86-р
захирамжийн хавсралт

| № | Зардлын төрөл | | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хулдаасан хэвлэл | | 28.82м2 | 8500 | 244970 |
| 2 | Тээвэр шатахууны зардал | Аи92 | 40л | 1800 | 72000 |
| | | Д түлш | 480л | 2150 | 1032000 |
| Бүгд | | | | | 1348970 |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 04 өдөр  Дугаар А/87  Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 6 дугаар багийн иргэн Д.Энхбаатарын (йс74012815) эзэмшлийн 5 дугаар багийн нутаг НИК шатахуун түгээх станцын баруун талд байрлах 000439481 тоот гэрчилгээний дугаартай, 6211000142 тоот нэгж талбарын дугаартай үйлчилгээний зориулалттай 1800 $м^2$ газрын эзэмших эрхийг 40 жилийн хугацаатайгаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг Газрын даамал (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Р.ЛХАГВАСҮРЭН

141 1173

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

## АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

**Нэг. Нийтийн албан тушаалтан**

| | | |
|---|---|---|
| Ургийн овог: [illegible] | Эцэг (эх)-ийн нэр: [illegible] | Нэр: [illegible] |
| Албан тушаал: [illegible] | Ажиллаж байгаа байгууллага: ЗДТГ | |
| Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: 2016.10.27 | Байгууллагын хаяг: ЗДТГ-ын байр | |
| Албан үүргийн төрөл: [illegible] | Тайлбар: 2018.06.15 а/88 Хорооны [illegible] | |

Сонирхлын зөрчилтэй эсэх Тийм ☐ Үгүй ☑

**Хоёр.Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал**

Нийтийн албан тушаалтан [signature]

би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

**Гурав.Сонирхлын зөрчил үүссэн тухай**

☐ Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд: гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:
_______________

☐ гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:
_______________

☐ байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:
_______________

☐ Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:
_______________

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

**Дөрөв.Баталгаажуулалт.**

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

[illegible] : [signature] /[signature]/
/албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

2018 он 06 сар 15 өдөр

---

### Шийдвэрлэсэн байдал

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх
Тийм ☐ Үгүй ☐

Хэрэв "Тийм" бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

☐ Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй

☐ Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй

☐ Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

.......................... : .......................... /........................../
/албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... он ... сар ... өдөр

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 15 өдөр Дугаар А/88 Хужирт сум

## Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэл журам"-ын 2.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны "Хүүхдийн хөгжил, хамгааллын жил болгон зарлах тухай" 06/05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны " Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн ажлын төлөвлөгөө батлах тухай" А/20 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүүхдийн хөгжил, хамгааллын жил"-ийн ажлын хүрээнд зохион байгуулагдах "Хайраа түгээе-Хамтдаа хөгжье" арга хэмжээний зардалд 100000 (нэг зуун мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Р.ЛХАГВАСҮРЭН

141 1175

Засаг даргын 2018 оны 6 –р
сарын 15 –ны өдрийн А/88 –р
захирамжийн хавсралт

| № | Зардлын төрөл | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Хүүхдийн урлагийн их наадамд амжилттай оролцсон 1 анги хамт олныг шагнаж урамшуулах | 1 | 30000 | 30000 |
| 2 | “Хайраа түгээе-Хамтдаа хөгжье” Дэвжээ | 1 | 70000 | 70000 |
| Бүгд | | | | 100.000 |

.

-oOo-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 06 сарын 15 өдөр    Дугаар А/89    Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Л.Цэдэв | Төрийн захиргааны асуудал хариуцсан түшмэл |
| Дуудлага худалдааны хөтлөгч: | Д.Мөнхбат | Газрын даамал |
| Тэмдэглэл хөтлөгч: | О.Алтанчимэг | Байгаль хамгаалагч |

